

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: ТӨА-2026/02-18/НА-СТА-НА-НТГ

ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2025 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2026 он

Дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Ахлах аудитор Т.Хүрэлбаатар

Утас: 7027-2248 Цахим хаяг: Khurelbaatart@audit.gov.mn

Аудитор Д.Бямбасүрэн

Утас: 7027-2287 Цахим хаяг: ByambasurenD@audit.gov.mn



Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар	3
Хүснэгтийн жагсаалт	4
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл.....	5
<i>Бүлэг А. Аймгийн болон сумдын ИТХ-аар 2025 онд нийт 160,239.7 сая төгрөгийн төсөө тодотгон баталсан нь анх батлагдсан төсөөс 1,895.0 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.....</i>	6
<i>А.1 Аймгийн 2025 оны төсвийн төсөлд Төв аймаг дахь Төрийн аудитын газраас 14,149.5 сая төгрөгийн орлого нэмж төлөвлөх санал дүгнэлт оруулсан байна. ..</i>	6
<i>А.2 Төв аймгийн 2025 оны төсвийн төсөл нь аймгийн хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй нийцэж байгаа боловч Бүсчилсэн хөгжлийн бодлогын заалтуудтай уялдуулан төлөвлөж эхлээгүй байна.</i>	7
<i>А.3 Төв аймаг 2025 онд нийт 158,344.7 сая төгрөгийн төсөө баталж, тодотголоор 1,895.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж 160,239.7 сая төгрөгийн төсөө баталсан байна.</i>	8
<i>А.4 Төв аймгийн ТЕЗ-ийн 2025 онд зарцуулах зарлагын нийт хэмжээг, аймаг, сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн хуралдаанаар 203,330.0 сая төгрөгөөр тодотгон баталсан байна.</i>	9
.....	11
<i>Бүлэг Б. Аймаг, сумдын татварын болон татварын бус орлого батлагдсан төлөвлөгөөнөөс 122,6 хувь буюу 20,673.0 сая төгрөгөөр давж биелсэн байна. ..</i>	11
<i>Б.1 Аймгийн төсвийн татварын ба татварын бус орлого төлөвлөснөөс 122,6 хувиар буюу 20,673.0 сая төгрөгөөр давж биелэснээс, 18 нэр төрлийн татварын орлогын төлөвлөгөө 22,944.1 сая төгрөгөөр буюу 3,5-314 хувиар давж биелсэн байна.....</i>	11
<i>БҮЛЭГ В. Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 онд зарцуулахаар батлагдсан нийт зардал төсвийн гүйцэтгэлийн тайлангаар 153,878.8 сая төгрөг буюу 75,7 хувийг зарцуулсан байна.</i>	14
<i>В1. Аймгийн 2025 оны төсвийн нийт зарлагын 80,7 хувийг урсгал, 18,7 хувийг хөрөнгийн, 1,1 хувийг эргэж төлөгдөх цэвэр зээлийн зардал эзэлж байна.</i>	14
<i>Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....</i>	17
ДҮГНЭЛТ: 18	
ЗӨВЛӨМЖ: 18	
Холбогдох байгууллагын санал:.....	19

Товчилсон үгийн тайлбар

БОАЖГ	Байгаль, орчин аялал жуулчлалын газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
БОЯ	Байгаль орчны яам
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
УИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХХС	Хоршоо хөгжүүлэх сан
МТТАТ	Малын тоо толгойн албан татвар
ХБГ	Хүлээгдэж буй гүйцэтгэл
ГХБХБГ	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар
ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
ТТАМ	Түгээмэл тархацтай ашигт малтмал
ҮХЭХ	Үл хөдлөх эд хөрөнгө
ОНХБО	Орон нутгийн хөрөнгө борлуулсны орлого
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
АТӨЯХАТ	Авто тээвэр өөрөө явагч хэрэгслийн албан татвар
ТГӨО	Төсөвт газрын өөрийн орлого

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Төв аймгийн орон нутгийн 2025 оны төсвийн төсөл.....	6
Хүснэгт 2. Төв аймгийн орон нутгийн 2025 оны төсвийн төсөлд өгсөн санал.....	7
Хүснэгт 3. Төв аймгийн 2025 оны аймаг, сумын ИТХ-аар батлагдсан төсөв	9
Хүснэгт 4. Төв аймгийн 2025 оны төсвийн орлогын төлөвлөгөө.....	10
Хүснэгт 5. ТЕЗ-ийн 2025 оны төсвийн зарлагын төлөвлөгөө	11
Хүснэгт 6. Төв аймгийн 2025 оны татварын ба татварын бус орлогын гүйцэтгэл	9
Хүснэгт 7. Татварын орлого тасарсан сумын жагсаалт.....	12
Хүснэгт 8. Төв аймгийн 2025 оны нийт зарлагын эдийн засгийн ангилал.....	13
Хүснэгт 9. Төв аймгийн 2025 оны төсвийн зарлагын төлөвлөгөө, гүйцэтгэлийг сумдаар ...	14
Хүснэгт 10. Төсвийн гүйцэтгэл хөтөлбөрөөр.....	15

<p>Аудит хийх үндэслэл, бүрэн эрх</p>	<p>Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл.</p>
<p>Аудитын зорилт</p>	<p>Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-т заасан бүрэн эрхийн хүрээнд Төв аймаг дахь Төрийн аудитын газрын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг үндэслэн Төв аймгийн ТЕЗ-ийн 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.</p> <p>Төв аймгийн ТЕЗ-ийн 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл үнэн зөв илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт гарган зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Нэгдсэн төсвийн орлого, зарлагын төлөвлөлтийн үндэслэл 2. Нэгдсэн төсвийн орлогын гүйцэтгэл 3. Нэгдсэн төсвийн зарлагын гүйцэтгэл
<p>Аудитын хамарсан хүрээ</p>	<p>Орон нутгийн төсөв болон улсын төсвөөс санхүүжилт авсан, төсвийн орлого бүрдүүлдэг байгууллага, аж ахуй нэгж, орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, аймгийн Засаг дарга, түүний харьяа байгууллага болон төсөл, арга хэмжээг гүйцэтгэгч нарын холбогдох үйл ажиллагааг хамрууллаа.</p>
<p>Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт</p>	<p>Аудитыг Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит, Тулгуур зарчим” стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг аудитын арга зүйг ашиглан аудитын хөтөлбөрт дурдсан хугацаанд шалгах хуудсаар нотлох зүйл цуглуулж, аудитын дүгнэлт, зөвлөмжийг боловсруулсан.</p> <p>Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглалаа.</p> <ul style="list-style-type: none"> • Төсвийн тогтвортой байдлын тухай хууль • Төсвийн тухай хууль • Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль • Нийгмийн даатгалын багц хуулиуд • Төрийн аудитын тухай хууль • Татварын багц хуулиуд • Холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн актууд
<p>Аудитын бүрэлдэхүүн, хугацаа</p>	<p>Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал удирдаж, аудитын менежер О.Амаржаргал чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Т.Хүрэлбаатар, аудитор Д.Бямбасүрэн нар гүйцэтгэв.</p> <p>Аудитын талбарын ажлыг 2026 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 2026 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр хүртэл гүйцэтгэж, аудитын тайлан, судалгааг ҮАГ-ийн Санхүүгийн аудитын газарт хүргүүлжээ.</p>

Бүлэг А. Аймгийн болон сумдын ИТХ-аар 2025 онд нийт 160,239.7 сая төгрөгийн төсөв тодотгон баталсан нь анх батлагдсан төсвөөс 1,895.0 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

А.1 Аймгийн 2025 оны төсвийн төсөлд Төв аймаг дахь Төрийн аудитын газраас 14,149.5 сая төгрөгийн орлого нэмж төлөвлөх санал дүгнэлт оруулсан байна.

Улсын Их Хурлаас Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийг 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдөр баталсан. Уг хуульд тусгагдсан зарим онцлог арга хэмжээг орон нутгийн төсвийг боловсруулж батлуулахад баримтлах талаар дараах чиглэл ирүүлсэн байна. Үүнд:

- Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар
- Төсвийн орлогын талаар
- Төсвийн зарлагын талаар
- Орон нутгийн хөгжлийн сангийн талаар

Төв аймгийн 2025 оны төсвийн төслийг Сангийн яам төсөвт төвлөрүүлэх суурь орлогыг 83,635.3 сая төгрөгөөр, улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 2,356.5 сая төгрөгөөр, ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг 24,987.5 сая төгрөгөөр хянаж УИХ-д өргөн мэдүүлсэн байна.

УИХ-аас Монгол Улсын 2025 оны төсвийн төслийг батлахдаа Төв аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг 24,987.5 сая төгрөгөөр, улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 2,356.5 сая төгрөгөөр, суурь орлогыг 78,915.3 сая төгрөгөөр буюу 4,720.0 сая төгрөгөөр бууруулан баталсан байна.

Төв аймгийн 2025 оны батлагдсан орлого эх үүсвэрийг өмнөх онтой харьцуулахад Төв аймгийн суурь орлого 78,915.3 сая төгрөг нь өмнөх оноос 24,855.9 сая төгрөгөөр буюу 31,4 хувиар өсгөж, ОНХС-д олгох орлогын шилжүүлэг 24,987.5 сая төгрөг нь өмнөх оноос 3,379.2 сая төгрөгөөр буюу 11,9 хувиар бууруулан төлөвлөсөн байна.

Аймгийн 2025 оны төсвийн төсөлд ОНХС-ийн орлогын шилжүүлгээр 24,987.5 сая төгрөгийг олгохоос сумдын ОНХС-д 16,109.4 сая төгрөг, аймгийн ОНХС-д 8,878.0 сая төгрөг хуваарилагдахаар байна.

Хүснэгт 1. 2025 оны төсвийн төсөл

Орлого, тусламжийн төрөл	УИХ-с баталсан	Нэмсэн дүн	/сая төгрөг/ 2025 оны төлөвлөгөөний төсөл
Орон нутгийн орлого	62,185.3	6,463.0	68,648.3
Аймгийн төсвийн орлого	16,730.0	2,480.7	19,195.7
Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг			
ОНХС-ийн шилжүүлэг	24,987.5		24,987.5
ОНХС-ийн хандив			
Төсвийн шилжих үлдэгдэл			12,696.5
Аймагт сумаас төвлөрүүлэх орлого			25,736.8
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих			15.0
Тогтоолоор баталсан орлогын дүн	103,902.8	8,943.7	151,279.8

Эх сурвалж: СТСХ-ээс ирүүлсэн 2025 ны төсвийн төсөл

Төв аймаг дахь Төрийн аудитын газраас Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд аймгийн 2025 оны төсвийн төсөлд холбогдох тооцоо, судалгааг хийж нийт 14,149.5 сая төгрөгийн орлого нэмэгдүүлэх, төсвийн зарлагыг 576.4 сая төгрөгөөр хэмнэх, үр ашгийг дээшлүүлэх боломжтой гэсэн санал дүгнэлтийг аймгийн ИТХ-ын хуралдаанд танилцуулан хэлэлцүүлсэн байна. Тухайлбал: Орон нутгийн төсвийн орлогын байгалийн ургамал ашигласны төлбөрийг 3.3 сая төгрөгөөр, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийг 120.0 сая төгрөгөөр, газрын төлбөрийг 5,126.4 мянган төгрөгөөр, хог хаягдлын үйлчилгээний хураамжийг 109.7 сая төгрөгөөр, үл хөдлөх хөрөнгийн албан татварыг 3,000.0 сая төгрөгөөр, малын тоо толгойн албан татварыг 4,031.1 сая төгрөгөөр, нийт 12,390.6 сая төгрөгөөр нэмэгдүүлэх. Аймгийн төсвийн орлогын ус ашигласны төлбөрийг 1,013.3 сая төгрөгөөр, хүү торгуулийн орлогыг 70.5 сая төгрөгөөр, нэр

ТӨВ АЙМГИЙН 2025 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

зааж ангилаагүй орлогыг 175.0 мянган төгрөгөөр, орон нутгийн өмчийн хөрөнгө борлуулсны орлогыг 500.0 сая төгрөгөөр, нийт 1,758.8 сая төгрөгөөр нэмэгдүүлэхээр тус тус санал оруулсан байна.

Хүснэгт 2. Төв аймгийн орон нутгийн 2025 оны төсвийн төсөлд өгсөн санал

/сая төгрөгөөр/

№	Орлогын нэр төрөл	Төсвийн төсөл	Нэмэгдүүлэх санал	Нэмэгдэх дүн
Сумын төсвийн орлого				
1	ТТАМ-ын нөөц ашигласны төлбөр	300.0	390.0	690.0
2	Байгалийн ургамал ашигласны төлбөр	120.0	120.0	240.0
3	Газрын төлбөр	3,512.0	5,126.4	8,638.4
4	Хог хаягдлын хураамж	350.0	109.7	459.7
5	ҮХЭХ-ийн албан татвар	11,187.0	3,000.0	14,187.0
6	Малын тоо толгойн албан татвар	0.0	4,031.1	4,031.1
	Дүн	15,169.0	12,390.6	27,559.6
Аймгийн төсвийн орлого				
1	Ус ашигласны төлбөр	2,200.0	1,013.3	3,213.3
2	Нэр зааж ангилаагүй орлого	500.0	175.0	675.0
3	Хүү торгуулийн орлого	1,200.0	70.5	1,270.5
4	ОНХБорлуулсны орлого	100.0	500.0	600.0
	Дүн	4,000.0	1,758.8	5,758.8
	Нийт орлого	19,169.0	14,149.5	33,318.5

Эх сурвалж: Төрийн аудитын газраас 2025 оны төсвийн төсөлд өгсөн санал

Аймгийн 2025 оны төсвийн төсөлд төсвийн орлогоор төвлөрүүлэхээр тусгасан 10 нэр төрлийн 23,330.0 сая төгрөгийн орлогоос 4 нэр төрлийн орлогыг 1,758.8 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 25,088.8 сая төгрөг болгох, сумдын орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр тооцсон 22 нэр төрлийн 65,536.9 сая төгрөгийн орлогоос 6 нэр төрлийн орлогыг 12,390.6 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 77,927.5 сая төгрөг болгох боломжтой талаар санал дүгнэлт гаргасан.

Аймгийн хэмжээнд төсвийн орлогын бааз суурийг өргөжүүлж, татварыг бүрэн ногдуулан ажиллахад тодорхой хэмжээний нөөц боломж байгаа нь орлогын төлөвлөгөөний биелэлт болон төсвийн шилжих үлдэгдлээр харагдаж байна.

A.2 Төв аймгийн 2025 оны төсвийн төсөл нь аймгийн хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй нийцэж байгаа боловч Бүсчилсэн хөгжлийн бодлогын заалтуудтай уялдуулан төлөвлөж эхлээгүй байна.

Монгол Улсын 2025 оны төсөв нь Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд шинэ 30 жилийн хөгжилд хөтлөх томоохон төслүүдийн бүтээн байгуулалтыг эхлүүлэх, эдийн засгийг тэлж, өсөлтийг айл өрхөд чиглүүлэх, бүсийн тэргүүлэх чиглэлд нийцсэн томоохон төсөл, арга хэмжээ, хөрөнгө оруулалт хийхийг уриалан дэмжсэн татварын цогц бодлого хэрэгжүүлэх зорилготой батлагдсан байна.

Аймгийн 2025 оны төсвийн төсөл нь агуулгын хувьд энэ зорилготой нийцэж боловсруулагджээ.

Тухайлбал, аймгийн суурь орлогыг 2024 оноос 34,479.2 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн, улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 7,838.7 сая төгрөгөөр бууруулж 9,001.9 сая төгрөг болгож төлөвлөсөн байна.

Аймгийн 2025 оны төсвийн төсөлд хөрөнгө оруулалтын ажлууд дараах байдалтай тусгагдсан байна:

- Аймгийн орон нутгийн хөгжлийн сангаар 7 төсөл арга хэмжээ 10,461.9 сая төгрөг,
- Шилжих үлдэгдлээр хийх хөрөнгө оруулалт 9 төсөл арга хэмжээ 5,290.0 сая төгрөг,
- Замын сангаар 9 ажил 2,000.0 сая төгрөг

Нийт 3 эх үүсвэрээс 24 хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, арга хэмжээг 25,193.5 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр төсөвлөсөн байна.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор “Төв аймгийг 2021-2026 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, 2025 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 08 дугаар тогтоолоор аймгийн Засаг даргын үйл

ажиллагааны хөтөлбөр, 2024 оны 9 дүгээр сарын 9-ний өдрийн 02 дугаар тогтоолоор аймгийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөө тус тус батлагдсан байна.

Аудитаар аймгийн төсвийн эх үүсвэрээр 2025 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг дээрх хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй нийцсэн эсэхийг тулгаж үзэхэд орон нутгийн төсвийн шилжих үлдэгдлийн эх үүсвэрээс 2025 онд санхүүжүүлэх ажлын жагсаалтын төсөлд тусгагдсан 5 сумын автомашин шинэчлэх зардал 400.0 сая төгрөг, аймгийн ЗДТГ-ын автомашины парк шинэчлэх зардал 300.0 сая төгрөгийн ажлаас бусад төсөл арга хэмжээний хувьд аймгийн дунд, богино хугацааны бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан зорилт, арга хэмжээтэй нийцсэн байна.

Монгол улсын Засгийн газрын 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 64 дүгээр тогтоолоор “Монгол Улсын Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-ыг баталсан байна. Төв аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн ээлжит бус I дүгээр хуралдааны 17 дугаар тогтоол болон сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны тогтоолуудаар 2025 оны төсвийг анх баталж, 2025 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн V дугаар хуралдааны 26 дугаар тогтоолоор тодотгон баталсан тул 2025 оны төсвийг Бүсчилсэн хөгжлийн бодлогын заалтуудтай уялдуулан төлөвлөж эхлээгүй байна.

А.3 Төв аймаг 2025 онд нийт 158,344.7 сая төгрөгийн төсөв баталж, тодотголоор 1,895.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж 160,239.7 сая төгрөгийн төсөв баталсан байна.

Төв аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн ээлжит бус I дүгээр хуралдааны 17 дугаар тогтоол болон сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны тогтоолуудаар 2025 оны төсвийн жилд нийт 158,344.7 сая төгрөгийн орлого бүрдүүлж, зарцуулахаар анх төсвөө баталж, 2025 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн V дугаар хуралдааны 26 дугаар тогтоол болон сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн хуралдааны тогтоолуудаар 1,895.2 сая төгрөгөөр бууруулан 160,239.7 сая төгрөг болгон баталсан байна. Аймгийн нийт төсвийн 73,0 хувийг сум орон нутгийн төсөв, 27,0 хувийг аймгийн төсөв эзэлж байна.

Төв аймгийн Төсвийн Ерөнхийлөн захирагч нь 2025 онд нийт 90,853.5 сая төгрөгийн татварын болон татварын бус орлого бүрдүүлж, улсын төсвөөс 2,154.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг авч, ОНХНС-аас 28,947.2 сая төгрөгийн орлогын шилжүүлгийн санхүүжилт авч, төсвийн болон ОНХС-ийн урд оны шилжих үлдэгдэл 32,374.8 сая төгрөг, 5 сумаас 24,110.1 сая төгрөгийг аймгийн төсөвт төвлөрүүлэхээр, сумдын үндсэн үйл ажиллагааны болон хандив тусламжийн орлого 4,015.2 сая төгрөг, сумдад 21,227.8 сая төгрөгийн санхүүжилт олгох, сумдын ОНХС-д 18,485.3 сая төгрөгийн санхүүжилт олгохоор баталсан байна.

Төсвийн тодотголоор улсын төсөвт 2,370.0 сая төгрөгийг төвлөрүүлэхээр, ОНХНС-аас авах орлогын шилжүүлэг 3,959.7 сая төгрөгөөр буурч 24,987.5 сая төгрөг болж, сумдад олгох санхүүжилт 4,374.2 сая төгрөгөөр хасагдаж 16,853.5 сая төгрөг болж, аймгийн нийт төсөв 1,895.0 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 3. Төв аймгийн 2025 оны аймаг, сумын ИТХ-аар батлагдсан төсөв

/сая төгрөгөөр/

№	Аймгийн төсөв	Анх баталсан		Тодотгол		Зөрүү	
		Нэр төрөл	Мөнгөн дүн	Нэр төрөл	Мөнгөн дүн	Нэр төрөл	Мөнгөн дүн
А	Аймгийн төсвийн суурь орлого	9	23,330.0	9	19,210.7	-	-4,119.3
1	Татварын орлого	4	23,125.0	4	18,520.0	-	-4,605.0
2	Татварын бус орлого	4	2,005.0	4	2,345.0	-	340.0
3	Татварын буцаан олголт	1	1,800.0	1	1,654.3	-	145.7
Б	Бусад орлогын эх үүсвэр		27,943.8		24,134.0		-3,809.8
4	Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг		2,154.0		-		-2,154.0
5	ОНХНС-с олгох орлогын шилжүүлэг		10,461.9		8,878.0		-1,583.9

ТӨВ АЙМГИЙН 2025 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

6	ОНХС-ын урд оны шилжих үлдэгдэл		2,931.4		2,539.5		-391.9
7	Шилжих үлдэгдэл		12,396.5		12,716.5		320.0
	Аймгийн төсвийн орлого	9	51,273.8	9	43,344.7	-	7,929.1
B	Сумын төсвийн суурь орлого	15	67,523.5	15	72,176.0	-	4,652.5
8	Татварын орлого	13	64,787.2	13	69,122.5	-	4,335.3
9	Татварын бус орлого	2	2,736.3	2	3,053.6	-	317.3
Г	Бусад орлогын эх үүсвэр		39,547.4		44,719.0		5,171.6
10	Үндсэн үйл ажиллагааны орлого		3,845.2		3,993.7		148.5
11	Хандив тусламжийн орлого		170.0		300.0		130.0
12	ОНХНС-с олгох орлогын шилжүүлэг		18,485.3		16,109.5		-2,375.8
13	Шилжих үлдэгдэл		17,046.9		24,315.8		7,268.9
	Сумын төсвийн орлого	15	107,070.9	15	116,895.0	-	9,824.1
	Нийт орлого	24	158,344.7	24	160,239.7	-	1,895.0

Эх сурвалж: Аймаг, сумдын ИТХ-ын тогтоолууд

УИХ-аас баталсан 2025 оны Төсвийн тухай хуулиар Төв аймгийн татварын ба татварын бус орлогыг 91,386.7 сая төгрөг, ОНХНС-аас олгох орлогын шилжүүлэг 24,987.5 сая төгрөг бүгд 116,374.2 сая төгрөг байна.

Аймгийн 2025 оны суурь орлогын төлөвлөгөө 2024 оноос 42,236.6 сая төгрөгөөр буюу 86,0 хувиар өссөн, ОНХНС-ийн шилжүүлэг 3,379.2 сая төгрөгөөр буюу 12,0 хувиар буурсан, улсын төсвөөс санхүүгийн дэмжлэг авахгүй 2,370.0 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 4. Төв аймгийн 2025 оны төсвийн орлогын төлөвлөгөө

/сая төгрөг/

Орлого, тусламжийн дүн	УИХ		Өсөлтийн дүн	
	2024 он	2025 он	Дүн	Хувь
Татварын ба татварын бус орлого	49,150.1	91,386.7	42,236.6	86.0%
Улсын төсвийн санхүүгийн дэмжлэг	16,840.6	-	-16,840.6	-100.0%
ОНХНС-ийн шилжүүлэг	28,366.8	24,987.5	-3,379.2	-12.0%
Дүн	94,357.5	116,374.2	22,016.8	23.0%

Эх сурвалж: Төсвийн тухай хууль, Төв аймгийн СТСХ-ийн 2025 оны төсвийн төслийн танилцуулга, мэдээлэл

А.4 Төв аймгийн ТЕЗ-ийн 2025 онд зарцуулах зарлагын нийт хэмжээг, аймаг, сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн хуралдаанаар 203,330.0 сая төгрөгөөр тодотгон баталсан байна.

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 онд зарцуулах зарлагын нийт хэмжээг, аймаг, сумдын ИТХ-ийн хуралдаанаар 203,682.7 сая төгрөгөөр баталсныг 2025 оны 9 дүгээр сарын 17-ний өдрийн V хуралдааны 26 дугаар тогтоолоор тодотгон 203,330.0 сая төгрөгөөр буюу 352.7 сая төгрөгөөр бууруулан баталсан байна.

Аймгаас сумдад хуваарилах санхүүгийн дэмжлэгийг 4,374.3 сая төгрөгөөр бууруулан 16,853.5 сая төгрөгөөр, аймгийн орон нутгийн хөгжлийн санд олгох шилжүүлгийг 2,375.8 сая төгрөгөөр бууруулан 16,109.5 сая төгрөгөөр тодотгон баталсан байна.

Тайлант онд Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх 29 хөтөлбөрт зориулан 203,330.0 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 135,389.9 сая төгрөгийг урсгал зардалд, 63,871.9 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, эргэж төлөгдөх цэвэр зээлд 4,068.2 сая төгрөгийг зарцуулахаар батлагджээ.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 онд зарцуулах нийт зардлын 24,987.5 сая төгрөгийг улсын төсвөөс, 133,959.6 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 39,571.7 сая төгрөгийг урьд оны үлдэгдлээс, 300.0 сая төгрөгийг хандив тусламжийн орлогоос, 517.5 сая төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос, 3,993.7 сая төгрөгийг зээлийн эргэн төлөлтөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

ТӨВ АЙМГИЙН 2025 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны төсвийн зарлагыг өмнөх онтой харьцуулахад батлагдсан төлөвлөгөө 203,330.0 сая төгрөгөөс 43,433.6 сая төгрөгөөр, гүйцэтгэл 153,878.8 сая төгрөгөөс 53,039.5 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна. Сангийн яамнаас Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 онд зарцуулах тодотгосон төсвийн зарлагыг 203,330.0 сая төгрөгөөр хянаж баталгаажуулсан байна.

Сүмбэр сумын ИТХ-ын 2024 оны 12 дугаар сарын 26-ний өдрийн II хуралдааны 04 дугаар тогтоолоор баталсан тогтоолын дүн 12.9 сая төгрөгөөр, Цээл сумын ИТХ-ын 2024 оны 12 дугаар сарын 27-ний өдрийн II хуралдааны 01 дүгээр тогтоолоор баталсан тогтоолын дүн 30.3 сая төгрөгөөр зөрүүтэй байна.

Тайлант онд Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх 23 хөтөлбөрт зориулан 203,330.0 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 135,284.7 сая төгрөгийг урсгал зардалд, 63,872.0 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, эргэж төлөгдөх цэвэр зээлд 4,173.4 сая төгрөг зарцуулахаар батлагджээ.

Хүснэгт 5. ТӨЗ-ийн 2025 оны төсвийн зарлагын төлөвлөгөө

/сая төгрөг/

Үзүүлэлт	2024 оны батлагдсан төлөвлөгөө	2025 он		
		Анх батлагдсан төлөвлөгөө	Тодотгосон төлөвлөгөө	Өмнөх онтой харьцуулбал
А	Б	1	2	3
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	159,896.4	203,682.7	203,330.0	43,433.6
УРСГАЛ ЗАРДАЛ	82,485.6	144,481.2	135,389.9	52,904.3
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	81,232.9	96,423.7	80,730.2	-502.7
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	25,510.3	31,807.6	30,340.9	4,830.7
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,196.0	3,975.4	3,816.9	620.9
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,122.2	24,696.1	23,184.1	1,061.9
Хангамж, бараа материалын зардал	1,500.8	1,470.8	1,623.7	122.9
Нормативт зардал	276.5	283.9	296.2	19.7
Эд хогшил, урсгал засварын зардал	2,397.3	2,268.3	3,307.4	910.0
Томилолт, зочны зардал	465.3	475.0	507.5	42.1
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,449.8	10,256.8	6,483.0	3,033.2
Бараа үйлчилгээний бусад зардал	22,189.0	21,066.1	11,170.4	-11,018.6
Хүү	125.7	123.6	123.6	-2.1
ТАТААС	198.2	234.6	82.0	-116.2
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,054.5	47,822.8	54,454.1	53,399.6
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	73,659.6	55,461.5	63,871.9	-9,787.6
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	3,751.3	3,740.0	4,068.2	316.9
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	159,896.4	203,682.7	203,330.0	43,433.6
Улсын төсвөөс санхүүжих	28,366.8	28,947.2	24,987.5	-3,379.3
Орон нутгийн төсвөөс санхүүжих	98,455.7	138,327.9	133,959.6	35,503.9
Урьд оны үлдэгдлээс санхүүжих	26,749.5	32,374.8	39,571.7	12,822.2
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	3,766.3	3,862.7	4,511.2	744.9
Бусад эх үүсвэр	2,558.1	170.0	300.0	-2,258.1
БАЙГУУЛЛАГЫН ТОО	63	64	64	1
АЖИЛЛАГСДЫН ТОО	1009	1101	1101	92

Эх сурвалж: Төв аймгийн 2025 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан.

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс тавьсан хоригт 2025 оны төсвийг үр ашигтай, хэмнэлттэй, алдагдалгүй батлах шаардлагатай гэсэн үндэслэлээр Улсын Их Хурлаас 2025 оны төсвийн тухай хуулийг батлахдаа төсвийн үр ашгийг дээшлүүлэх, урсгал зардлыг бууруулах, төсөвт байгууллагын үйл ажиллагааны зарим зардлыг хэсэгчлэн болон бүрэн бууруулахаар өгсөн чиглэлийг үндэслэн аймгийн 2025 оны төсвийг баталсан байна.

Төсвийн ерөнхийлөн захирагч тайлант онд төсөвт байгууллагыг 64, ажиллагсдын тоог 1101 байхаар тооцож төлөвлөсөн байна. Засгийн газрын 2025 оны 37 дугаар тогтоолын 4 дүгээр зүйлийн 4.26 дахь заалтын дагуу Төв аймгийн Засаг даргын 2025 оны 03 дугаар сарын 21-ны өдрийн А/110 дугаар захирамжаар аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд Архивын хэлтсийг шинээр байгуулсан байна. Мөн Төв аймгийн Засаг даргын 2025 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн А/217 дугаар захирамжаар сумдын Тамгын газрын орон тоо, бүтцийг шинэчлэн баталснаас орон тоо 92-оор нэмэгдсэн байна.

Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч 2025 оны төсвийн тодотголд дараах өөрчлөлтүүдийг тодотгон тусгасан байна. Үүнд:

- Улсын төсвөөс аймагт олгох санхүүгийн дэмжлэг оны эхэнд 2,154.0 сая төгрөгөөр батлагдсан бөгөөд төсвийн хэмнэлттэй холбоотойгоор зардлыг бууруулан баталсаны улмаас тодотголоор улсын төсөвт 2,370.0 сая төгрөг төвлөрүүлэхээр батлагдсан байна. Улсын төсөвт орлого төвлөрүүлэгч аймаг болсны улмаас сумдад олгох санхүүгийн дэмжлэг 4,374.3 сая төгрөгөөр буурсан байна.
- Төсвийн тодотголоор цалин хөлс 1,466.7 сая төгрөгөөр, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл 158.4 сая төгрөгөөр, байр ашиглахтай холбоотой тогтмол зардал 1,512.0 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 3,773.8 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардал 9,895.7 сая төгрөгөөр тус тус бууруулж, хангамж бараа материалын зардал 152.9 сая төгрөгөөр, нормативт зардал 12.4 сая төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардал 1,039.1 сая төгрөгөөр, дотоод албан томилолтын зардал 32.4 сая төгрөгөөр, хөрөнгийн зардлыг 8,410.5 сая төгрөгөөр, урсгал шилжүүлэг 6,631.2 сая төгрөгөөр нэмэгдүүлж, оны эхний баталсан төсвөөс нийт дүнгээр 352.7 сая төгрөгөөр төсвийг Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас бууруулан баталсан байна.

Бүлэг Б. Аймаг, сумдын татварын болон татварын бус орлого батлагдсан төлөвлөгөөнөөс 122,6 хувь буюу 20,673.0 сая төгрөгөөр давж биелсэн байна.

Б.1 Аймгийн төсвийн татварын ба татварын бус орлого төлөвлөснөөс 122,6 хувиар буюу 20,673.0 сая төгрөгөөр давж биелэснээс, 18 нэр төрлийн татварын орлогын төлөвлөгөө 22,944.1 сая төгрөгөөр буюу 3,5-314 хувиар давж биелсэн байна.

Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татварын болон татварын бус орлогыг аймаг, сумдын ИТХ-ын хуралдаанаас нийт 91,386.8 сая төгрөгөөр тодотгон баталсан. Гүйцэтгэлээр нийт 112,059.8 сая төгрөгийн татварын ба татварын бус орлогыг төвлөрүүлж, батлагдсан төлөвлөгөөг 20,673.0 сая төгрөгөөр буюу 122,6 хувиар давуулан биелүүлсэн байна.

Аймгийн төсвийн татварын ба татварын бус орлого төлөвлөснөөс 157,7 хувиар буюу 11,075.0 сая төгрөгөөр давж биелэснээс, 5 нэр төрлийн татварын орлогын төлөвлөгөө 10,971.3 сая төгрөгөөр буюу 9-67 хувиар давж биелсэн байна. Тухайлбал:

- ААНОАТ 15,000.0 сая төгрөг төвлөрүүлэхээс, гүйцэтгэлээр 25,070.7 сая төгрөг төвлөрч, 167,3 хувиар буюу 10,070.7 сая төгрөгөөр давж биелсэн байна. Энэ нь “Сангийн сайдын 2022 оны А7 дугаар тушаалаар баталсан “Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлогыг аймаг, нийслэлийн төсөвт хуваарилах, үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих журам”-н дагуу орон нутагт хуваарилагдаагүй орлогыг Татварын ерөнхий газар болон Сангийн яамнаас төвлөрүүлэн дахин хуваарилдаг зохицуулалт үйлчилж байгаа, мөн и-баримтыг тухайн орон нутгаар хэвлэх, ашигтай ногдолтой тайлан гаргавал ногдлыг нь бусад татварын албатай хамтарч ажиллах замаар төсөвт төвлөрүүлсэн орлогоос 40 хувь нь манай орон нутгийн төсөвт хуваарилагдаж байгаатай холбоотой байна.
- Хүү торгуулийн орлого 610.9 сая төгрөгөөр буюу 35,9 хувиар, нэр зааж ангилагдаагүй орлого 212.2 сая төгрөгөөр буюу 42,4 хувиар тус тус давж биелсэн байна.

ТӨВ АЙМГИЙН 2025 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

Тайлант онд сумдын татварын ба татварын бус орлого төлөвлөснөөс 113,3 хувиар буюу 9,597.9 сая төгрөгөөр давж биелэснээс, 17 нэр төрлийн татварын орлогын төлөвлөгөө 11,889.5 сая төгрөгөөр буюу 3-314 хувиар давж биелсэн байна. Тухайлбал:

- Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхэлсний орлогын албан татвар 39,032.7 сая төгрөг төвлөрүүлэхээс, гүйцэтгэлээр 43,340.2 сая төгрөг төвлөрүүлж, 11,0 хувиар буюу 4,307.4 сая төгрөгөөр давж биелсэн байна. Энэ нь татварын орлогыг нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн хяналт, бүртгэл, зөвлөн туслах үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлж татвар төлөгчдийн хамрагдалтыг нэмэгдүүлсэнтэй холбоотой байна.
- Газрын дуудлага худалдааны орлогын төлөвлөгөө 54.1 сая төгрөг, гүйцэтгэлээр 1,575.6 сая төгрөг орж 1,521.4 сая төгрөгөөр давж биелсэн нь газрын дуудлага худалдааны орлогыг хэт багаар төлөвлөсөнтэй холбоотой байна.
- Суутгагчийн хувь хүнд олгосон орлогоос суутгасан албан татварын орлогод 680.0 сая төгрөгийг төвлөрүүлэхээс 2,136.9 сая төгрөг төвлөрч, 314,3 хувиар буюу 1,456.9 сая төгрөгөөр давж биелсэн нь Эрдэнэс таван толгойн ногдол ашгаас суутгасан татвар, мөн уралдаан тэмцээн 5%, хяналт шалгалтын актын нөхөн төлбөр зэрэг орлогоос хамаарсан байна.

Дээрхээс гадна “E-TUB аппликейшн”-г Газар зохион байгуулалт геодези зураг зүйн ерөнхий газрын зураг зүйн ерөнхий газрын “Орон зайн өгөгдөл”-тэй холбож хийсэн шинэчлэлийг ашиглан Төв аймгийн Засаг даргын 2025 оны 10-р сарын 20-ны өдрийн А/553 тоот “Татварын хуулийн хэрэгжилтийг хангах тухай” захирамж, ЗДТГ-ын даргын баталсан “Аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхлэгч татвар төлөгчийн шинэчилсэн бүртгэл, тооллого хийх ажлын удирдамж”-ийг батлуулан татвар төлөгчийн шинэчилсэн бүртгэл тооллогыг зохион байгуулсан байна. Тооллогын ажлын үр дүнгээр Аймгийн төр захиргааны болон бусад байгууллагын мэдээллийн зөрүүг арилгах, бүртгүүлээгүй үйл ажиллагаа эрхэлж буй хувь хүн, хуулийн этгээдийг татвар төлөгчөөр бүртгэх татварын зөвлөгөө, үйлчилгээ үзүүлэх, газар зүйн мэдээллийн системд суурилсан газар, үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэл, үнэлгээ, татвар, төлбөрийн нэгдсэн системийг хөгжүүлэх суурь судалгааны мэдээлэл цуглуулах, татвар төлөгчид татварын хууль тогтоомжийн талаар сурталчилах, татвар төлөгчид татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд нь зөвлөн туслах, хуулийн хэрэгжилтэд хяналт тавих замаар далд эдийн засгийг илрүүлэх, бүртгэлжүүлэх, аймаг, сумын төсвийн татварын орлогын нэмэлт эх үүсвэр бий болгох, татварын орлогын төлөвлөгөөг биелэх нөхцөл бүрдсэн байна.

Аймаг, сумдын төсөвт төвлөрүүлэх 2025 оны татварын орлого гүйцэтгэлээр 105,185.2 сая төгрөг, үүнээс татварын буцаан олголт 1,654.3 сая төгрөгийг хасаж тооцоход 103,530.8 сая төгрөг төвлөрч, төлөвлөснөөс 120,4 хувиар буюу 17,845.6 сая төгрөгөөр, Татварын бус орлого 4,047.2 сая төгрөг батлагдснаас 6,874.7 сая төгрөг буюу 2,827.5 сая төгрөгөөр тус тус илүү төвлөрсөн байна. Батлагдсан төлөвлөгөөгөөр ОНХНС-ийн орлогын шилжүүлэг 24,987.5 сая төгрөг батлагдсанаас гүйцэтгэлээр 24,820.0 сая төгрөгийн санхүүжилт авч, 167.4 сая төгрөгөөр дутуу санхүүжигдсэн байна.

Хүснэгт 6. Төв аймгийн 2025 оны татварын ба татварын бус орлогын гүйцэтгэл

/сая төгрөг/

№	Орлогын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
A	ТАТВАРЫН ОРЛОГО	87,339.6	105,185.2	17,845.6	120.4
1	Цалингийн ашиг	39,032.8	43,461.1	4,428.3	111.3
2	Үйл ажиллагааны ОАТ	1,250.0	2,008.4	758.4	160.7
3	Суутгагчийн хувь хүнд олгосон орлогоос суутгасан албан татвар	680.0	2,137.0	1,457.0	314.3
4	МТТТатвар	1,354.7	1,627.9	273.1	120.2
5	ҮХЭХ-ийн албан татвар	11,359.8	11,072.0	- 287.8	97.5
6	Галт зэвсгийн албан татвар	33.0	34.2	1.2	103.5
7	Тэмдэгт	3,281.0	3,560.6	279.6	108.5
8	Байгалийн ургамал	3.0	0.6	- 2.4	19.9
9	Газрын төлбөр	3,836.6	4,596.5	759.9	119.8

ТӨВ АЙМГИЙН 2025 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

10	Ус ашигласны төлбөр	2,239.4	2,236.7	-	2.7	99.9
11	Ойн төлбөр	1,732.5	323.1	-	1,409.4	18.7
12	Агнуурын нөөц аш.төлбөр	1,942.4	1,381.9	-	560.5	71.1
13	Хог хаягдлын хураамж	390.1	511.9		121.8	131.2
14	ТТАМ ашигласны төлбөр	120.0	195.3		75.3	162.7
15	ҮХЭХ борлуулсны албан татвар	840.0	960.4		120.4	114.3
16	Иргэдийн хадгаламжийн хүүгийн орлого (суутган-3)	3,520.0	3,645.0		125.0	103.6
17	Газрын дуудлага худалдаа	54.2	1,617.1		1,563.0	2,985.1
19	ААНОАТ	15,000.0	25,070.8		10,070.8	167.1
20	АТӨЯХ-ийн албан татвар	670.0	744.7		74.7	111.1
Б	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,047.2	6,874.7		2,827.5	169.9
1	Түрээсийн орлого	104.7	176.4		71.7	168.5
2	ТГӨОрлого	17.5	186.2		168.7	1,064.2
3	Нэр зааж ангилагдаагүй	720.5	1,099.8		379.3	152.2
4	Хүү торгууль	4,758.8	6,979.0		2,220.2	146.6
5	Орон нутгийн өмч хөрөнгө борлуулсны орлого	100.0	87.5	-	12.5	87.5
6	Буцаан олголт	- 1,654.3	- 1,654.3		-	100.0
В	ТАТВАРЫН БА ТАТВАРЫН БУС ОРЛОГЫН ДҮН	91,386.8	112,059.8		20,673.0	122.6

Эх сурвалж: Төсвийн тухай хууль, Төв аймгийн СТСХ-ийн 2025 оны төсвийн төслийн танилцуулга, мэдээлэл

Тайлант онд аймаг, сумдын 5 нэр төрлийн татварын орлого 2,272.7 сая төгрөгөөр тасарсан байна. Тухайлбал: Хуулийн этгээдийн үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар 319.2 сая төгрөгөөр, ойн нөөц ашигласны төлбөр 1,409.4 сая төгрөгөөр, ан амьтны нөөц ашигласны төлбөр 560.5 сая төгрөгөөр, аймгийн төсвийн орлогын ус ашигласны төлбөр нь 28.6 сая төгрөгөөр тус тус тасарсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1-д "Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь, төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт, төсвийн зарцуулалт болон бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ" гэсэн заалт хэрэгжээгүй байна.

Хүснэгт 7. Татварын орлого тасарсан сумын жагсаалт

/сая төгрөг/

№	Сумын нэр	Орлогын			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Тасарсан хэмжээ	Хувь
1	Алтанбулаг	2,273.3	2,269.3	-4,000.0	99.8%
2	Батсүмбэр	2,959.4	2,581.4	-378.0	87.2%
3	Баян-Өнжүүл	767.2	702.2	-65.0	91.5%
4	Баянхангай	820.9	769.6	-51.3	93.7%
5	Дэлгэрхаан	630.0	458.3	-171.3	72.8%
6	Мөнгөнморьт	1,464.1	857.3	-606.8	58.6%
	Нийт дүн	8,915.1	7,638.6	1,276.5	85.6%

Эх сурвалж: Төв аймгийн 2025 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан.

Хуулийн этгээдийн үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын орлогын төлөвлөгөө тасарсан нь "Монгол компосайт минералс" ХХК, "Эбису мийт" ХХК, "Скайкатеринг" ХХК, "Монголын хөл бөмбөгийн холбоо", "Тэгш мандал трейд" ХХК, "Цонжин кибер" сургууль зэрэг аж ахуйн нэгжүүд нь үйл ажиллагааны нөхцөл байдлаас хамааран төлөлтийн графикаар, эзэн холбогдогчгүй 3, хөрөнгө шатаж галын дүгнэлт гарсан 1, нэхэмжлэх хүргүүлэн данс хаалттай 38, маргаантай 1, хөрөнгийн битүүмжтэй 1 ААН, огт үйл ажиллагаа явуулахгүй зэрэг шалтгаанууд нөлөөлж байна.

Ойн нөөц ашигласны төлбөрийн орлого тасарсан нь Батсүмбэр, Мөнгөнморьт сумууд нь нийт төлөвлөгөөний 90 хувийг биелүүлэхээр төлөвлөсөн ч 2025 оны хувьд хуурайшилт ихтэй, ойгоос мод бэлтгэх, ойн дагалт ашиглахыг Засаг даргын захирамжаар хориглосонтой холбоотой байна.

Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого тасарсан нь 14 суманд 1,942.3 сая төгрөгийн төлөвлөгөөтэйгөөс идлэг шонхор шувуу бариулахаар төлөвлөсөн сумдаас агнуурын нөөц хомс байсантай холбоотой байна.

БҮЛЭГ В. Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 онд зарцуулахаар батлагдсан нийт зардал төсвийн гүйцэтгэлийн тайлангаар 153,878.8 сая төгрөг буюу 75,7 хувийг зарцуулсан байна.

В1. Аймгийн 2025 оны төсвийн нийт зарлагын 80,7 хувийг урсгал, 18,7 хувийг хөрөнгийн, 1,1 хувийг эргэж төлөгдөх цэвэр зээлийн зардал эзэлж байна.

Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5.1-д заасны дагуу, 2025 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангаар нийт зарлага тодотгон батлагдсан төлөвлөгөөгөөр 203,330.0 сая төгрөг, гүйцэтгэлээр 153,878.8 сая төгрөгийг зарцуулж, 49,451.2 сая төгрөгөөр дутуу буюу гүйцэтгэл 75,7 хувь байна. Энэ нь урсгал зардал 11,192.9 сая төгрөгөөр хэмнэлттэй, хөрөнгийн зардал 35,914.6 сая төгрөгөөр зарцуулагдаагүй, эргэж төлөгдөх цэвэр зээлээс 2,343.7 сая төгрөгийг зарцуулагдаагүй, 1,901.6 сая төгрөгийн эх үүсвэр бүрдээгүйтэй холбоотой байна.

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд улсын төсвөөс Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн санхүүжилт 24,820.0 сая төгрөг, орон нутгийн төсвийн орлогоор 128,187.3 сая төгрөг, эргэж төлөгдөх цэвэр зээл 2,617.7 сая төгрөг, туслах үйл ажиллагааны орлого 66.3 сая төгрөг, хандив тусламжийн орлогоос 104.2 сая төгрөг нийт 155,795.5 сая төгрөг төвлөрсөн байна.

Үндсэн үйл ажиллагааны орлогод 575.0 сая төгрөг төлөвлөж баталснаас, гүйцэтгэлээр төвлөрүүлсэн 38.6 сая төгрөгөөс Эрдэнэ сумын төрийн албан хаагчдын орон сууцны төлбөр 24.2 сая төгрөг, Баянчандмань сумын мод тарих хандив 1.1 сая төгрөг, Борнуур сумын наадмын үйл ажиллагааны хандив 0.5 сая төгрөг, Архивын хэлтсийн архивын лавлагааны орлого 8.2 сая төгрөг, аймгийн ЗДТГ-ын архивын лавлагааны орлого 4.6 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогод тайлагнасан байна.

Хандив тусламжийн орлого 300.0 сая төгрөгөөр төлөвлөж баталснаас 104.2 сая төгрөгийг төвлөрүүлж, 195.8 сая төгрөгөөр төвлөрүүлээгүй байна.

Тусгай зориулалттай сангуудын батлагдсан төлөвлөгөөгөөр 3,993.8 сая төгрөгийн эргэн төлөлт төвлөрүүлэхээс 2,092.2 сая төгрөг бүрдүүлж 1,901.6 сая төгрөгийн эх үүсвэр дутуу бүрдүүлсэн буюу зээлийн эргэн төлөлт хангалтгүй байгаа нь гүйцэтгэлд нөлөөлж байна.

Хүснэгт 8. Төв аймгийн 2025 оны нийт зарлагын эдийн засгийн ангилал

/сая төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ	2024 оны гүйцэтгэл	2025 оны				
		Анх батлагдсан	Тодотгосон төлөвлөгөө	Гүйцэтгэл	хувь	зөрүү
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	100,839.3	203,682.7	203,330.0	153,878.8	75.7	49,451.2
А. Урсгал зардал	50,256.6	144,481.2	135,389.9	124,197.0	91.7	11,192.9
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	24,284.5	31,807.6	30,340.9	29,364.5	96.8	976.4
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,996.9	3,975.4	3,816.9	3,659.2	95.9	157.8
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,555.3	24,696.1	23,184.1	22,249.5	96.0	934.6
Хангамж, бараа материалын зардал	1,409.1	1,470.8	1,623.7	1,188.7	73.2	434.9
Нормативт зардал	274.0	283.9	296.2	253.0	85.4	43.2

ТӨВ АЙМГИЙН 2025 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

Эд хогшил, урсгал засварын зардал	2,278.4	2,268.3	3,307.4	2,584.8	78.2	722.6
Томилолт, зочны зардал	421.7	475.0	507.5	367.6	72.4	139.8
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,334.5	10,256.8	6,483.0	4,585.4	70.7	1,897.6
Бараа үйлчилгээний бусад зардал	15,036.9	21,066.1	11,170.4	6,250.5	56.0	4,919.9
Дотоодын зээлийн үйлчилгээний төлбөр	125.7	123.6	123.6	123.6	100.0	-
ТАТААС	198.2	234.6	82.0	41.5	50.7	40.5
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	924.7	47,822.8	54,454.1	53,528.5	98.3	925.6
Б. ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	52,447.5	55,461.5	63,871.9	27,957.3	43.8	35,914.6
В. Эргэж төлөгдөх цэвэр зээл	1,424.9	3,740.0	4,068.2	1,724.5	42.4	2,343.7

Эх сурвалж: Төв аймгийн 2025 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны төсвийн зарцуулалтыг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулбал нийт дүнгээр 53,039.5 сая төгрөг буюу 52.6 хувиар, урсгал зардал 73,940.4 сая төгрөг буюу 1.4 дахин, эргэж төлөгдөх цэвэр зээл 299.5 сая төгрөг буюу 21.0 хувиар нэмэгдэж, хөрөнгийн зардал 24,490.2 сая төгрөг буюу 53.3 хувиар буурсан байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны төсвийн нийт зарлагын 80.7 хувь буюу 124,197.0 сая төгрөгийг урсгал зардал, 18.2 хувь буюу 27,957.3 сая төгрөгийг хөрөнгийн зардал, 1.1 хувь буюу 1,724.5 сая төгрөгийг эргэж төлөгдөх цэвэр зээл эзэлж байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар тайлант онд цалин, шимтгэлийн зардал 1,134.2 сая төгрөгөөр, байр ашиглахтай холбоотой тогтмол зардал 934.6 сая төгрөгөөр, хангамж бараа материалын зардал 434.9 сая төгрөгөөр, нормативд зардал 43.2 сая төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардал 722.6 сая төгрөгөөр, дотоод албан томилолтын зардал 139.8 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ, төлбөр хураамжийн зардал 1,897.6 сая төгрөгөөр, бараа ажил үйлчилгээний зардал 4,919.9 сая төгрөгөөр, бусад урсгал шилжүүлэг 925.6 сая төгрөгөөр, байгууллагад олгох татаас 40.5 сая төгрөгөөр, хөрөнгийн зардлыг хязгаарласнаар 35,914.6 сая төгрөгөөр, эргэж төлөгдөх цэвэр зээл 2,343.7 сая төгрөгөөр тус тус хэмнэсэн байна.

Төсвийн зарлага хэмнэгдэн гарахад дараах хүчин зүйлс нөлөөлсөн байна. Үүнд:

1.Улсын төсвийг алдагдалгүй байлгаж орлого, зарлагын тэнцвэрийг хангаснаар төсвийн суурь зарлага урьд оноос буурч батлагдсан байна.

2.Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд зарим зардлуудыг царцааж, бууруулсан байна.

3.Улсын төсвийн орлого төвлөрүүлэлттэй холбогдуулан 2025 оны 10 сараас төсвийн хэмнэлтийн горимд шилжиж, төсвийн зарцуулах эрхийг эрэмбэлэн нээж, төсвийн хөрөнгө оруулалтын зардлуудыг хязгаарласан нь тус тус нөлөөлжээ.

Хүснэгт 9 Төв аймгийн 2025 оны төсвийн зарлагын төлөвлөгөө, гүйцэтгэл сумдаар

/сая төгрөг/

Сум	Зарлага				Сум	Зарлага			
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
Алтанбулаг	3,551.2	2,431.1	68.5	1,119.9	Дэлгэрхаан	1,980.2	1,564.6	79.0	415.6
Аргалант	2,532.3	2,125.3	83.9	407.0	Жаргалант	3,765.2	2,735.5	72.7	1,029.7
Архуст	1,773.0	1,255.0	70.8	517.9	Заамар	9,673.7	7,507.9	77.6	2,165.8
Батсүмбэр	4,406.6	3,137.4	71.2	1,269.2	Зуунмод	21,967.6	16,319.7	74.3	5,647.9
Баян	7,666.3	2,339.1	30.5	5,327.2	Лүн	3,329.8	2,979.4	89.5	350.4
Баяндэлгэр	2,095.6	1,554.8	74.2	540.8	Мөнгөнморьт	3,991.9	2,682.4	67.2	1,309.6
Баянжаргалан	4,758.5	1,823.5	38.3	2,935.0	Өндөрширээт	2,313.5	1,945.2	84.1	368.4
Баян-Өнжүүл	2,658.5	1,569.5	59.0	1,089.1	Сүмбэр	1,930.4	1,788.4	92.6	142.1
Баянхангай	2,120.3	1,802.3	85.0	318.0	Сэргэлэн	25,856.1	23,482.2	90.8	2,374.0
Баянцагаан	2,804.8	1,770.8	63.1	1,034.0	Угтаал	2,707.6	2,325.2	85.9	382.5
Баянцогт	2,397.6	1,877.7	78.3	520.0	Цээл	2,580.7	2,124.8	82.3	455.9
Баянчандмань	4,476.3	2,877.8	64.3	1,598.5	Эрдэнэ	3,506.2	3,085.3	88.0	420.9
Борнуур	2,906.8	2,329.1	80.1	577.7	Эрдэнэсант	3,170.2	2,348.4	74.1	821.8
Бүрэн	2,827.1	2,160.5	76.4	666.6	Төв шууд	69,581.6	53,935.9	77.5	16,645.7
НИЙТ ДҮН						203,330.0	153,878.8	75.7	49,451.2

ТӨВ АЙМГИЙН 2025 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

Эх сурвалж: Төв аймгийн 2025 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан

Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийн эх үүсвэр дутуу бүрдсэн, зээлийн шалгаруулалтад тэнцсэн төсөл арга хэмжээ ирээгүйгээс 2,343.7 сая төгрөгөөр төсвийн зарлагыг хэмнэхэд нөлөөлсөн байна.

Орон нутгийн төсвийн төвлөрүүлэн захирагчдын батлагдсан төсөв 99,942.9 сая төгрөг, төвлөрсөн байгууллагуудын төсөв 53,935.9 сая төгрөг, нийт батлагдсан төсөв 30,0-92,6 хувь буюу 153,878.8 сая төгрөгийн гүйцэтгэлтэй зарцуулагдсан байна. Үүнээс:

Баянхангай, Лүн, Сүмбэр, Сэргэлэн, Угтаалцайдам, Эрдэнэ сумдын нийт батлагдсан төсөв 85,0-92,6 хувь буюу 35,462.7 сая төгрөг, Баян, Баянжаргалан, Баян-Өнжүүл, Баянцагаан, Баянчандмань, Мөнгөнморьт сумд 30,0-67,2 хувь буюу 13,063.0 сая төгрөг гүйцэтгэлтэй зарцуулагдсан байна.

Төсвийн гүйцэтгэл хөтөлбөрөөр

Төсвийн гүйцэтгэлийг хөтөлбөрөөр авч үзвэл орон нутгийн гүйцэтгэх засаглал удирдлага хөтөлбөр 93,6 хувь буюу 9,804.1 сая төгрөгөөр, авто замын хөтөлбөр 43,8 хувь буюу 22,364.5 сая төгрөгөөр, эмнэлгийн тусламж үйлчилгээ хөтөлбөр 40,2 хувь буюу 5,258.5 сая төгрөгөөр хэмнэсэн нь нийт төсвийн гүйцэтгэлд нөлөөлсөн байна.

Хүснэгт 10. Төсвийн гүйцэтгэл хөтөлбөрөөр

<i>/сая төгрөг/</i>					
№	Хөтөлбөрийн нэр	Төсөв	Гүйцэтгэл	Хэтрэлт, хэмнэлт	Хувь
1	Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа	7,258.9	5,805.2	1,453.7	80.0%
2	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	75,482.8	65,678.7	9,804.1	87.0%
3	Засгийн газрын өрийн үйлчилгээ	123.6	123.6	-	100.0%
4	Төрийн архив, албан хэрэг хөтлөлт	232.8	184.2	48.6	79.1%
5	Худалдан авах ажиллагаа	335.2	325.4	9.7	97.1%
6	Төрийн өмчийн эрхийг хэрэгжүүлэх	603.0	600.5	2.5	99.6%
7	Санхүүгийн хяналт, дотоод аудит, эрсдэлийн удирдлага	571.4	540.0	31.3	94.5%
8	Доод шатны төсвөөс дээд шатны төсөвт төвлөрүүлэх орлого	29,293.5	29,293.5	-	100.0%
9	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх	2,725.7	1,302.5	1,423.2	47.8%
10	Мал аж ахуйг хөгжүүлэх	2,532.3	1,473.9	1,058.3	58.2%
11	Авто зам	40,071.2	17,706.7	22,364.5	44.2%
12	Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага	6,224.6	3,743.3	2,481.3	60.1%
13	Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх	298.0	238.4	59.6	80.0%
14	Эмнэлгийн тусламж үйлчилгээ	8,791.1	3,532.6	5,258.5	40.2%
15	Биеийн тамир спорт	1,525.0	1,189.3	335.7	78.0%
16	Соёл урлаг	4,863.2	3,839.8	1,023.5	79.0%
17	Сургуулийн өмнөх боловсрол	3,753.8	3,233.5	520.3	86.1%
18	Ерөнхий боловсрол	14,751.2	11,986.3	2,764.9	81.3%
19	Мэргэжлийн боловсрол	2,153.2	1,913.3	240.0	88.9%
20	Насан туршийн боловсрол	31.8	31.8	0.0	100.0%
21	Нийгмийн халамж	245.5	144.2	101.3	58.7%
22	Ахмад настны хөгжил хамгаалал	718.9	481.6	237.3	67.0%
23	Ангилалдаагүй бусад	743.4	510.3	233.1	68.6%
Нийт дүн		203,330.0	153,878.8	49,451.2	75.7%

Эх сурвалж: Төв аймгийн 2025 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Монгол улсын Ерөнхий аудиторын 2022 оны А/59 дүгээр тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэл”, А /89 дүгээр тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагаас Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэлийг хэрэгжүүлэх заавар”-ын дагуу хэрэгжилтийг Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын хүрээнд үзэхэд Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчсөн 263.6 сая төгрөгийн зөрчил илэрснээс 28.3 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 123.9 сая төгрөгийн зөрчлийг таслан зогсоох албан шаардлага, 111.3 сая төгрөгийн зөрчилд алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлсэн байна. Тухайлбал:

- Гарын бэлэг, хоол, тэмцээн уралдаанд зардал гаргасан, илүү олгосон цалин хөлс, албан томилолт нийт 186.5 сая төгрөгийг зарцуулсан зөрчлийг таслан зогсоож, цаашид давтан гаргахгүй байх албан шаардлага, зөвлөмж өгч шийдвэрлэв.
- Засаг даргын нөөцөөс дэмжлэг олгох, хүндэтгэл үзүүлэх болон урьдчилан төлөвлөх боломжтой зардалд 77.1 сая төгрөгийг зарцуулсан зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх албан шаардлага, зөвлөмж өгч шийдвэрлэв.
- Төрийн албаны тухай хуульд Засаг даргын орлогч нь төрийн улс төрийн албан хаагч гэж заасан байх боловч түүнийг сонгуулийн үр дүнгээр албан тушаалаас чөлөөлөхөд тэтгэмж олгох талаар зохицуулаагүй байхад хуулиар зөвшөөрснөөс бусад тэтгэмж олгосныг хууль зүйн үндэслэлгүй гэж үзэн аймаг, сумдын Засаг даргын орлогч нарт 44.9 сая төгрөгийн тэтгэмж олгосон зөрчлийг таслан зогсоож, цаашид давтан гаргахгүй байх албан шаардлага өгч шийдвэрлэв.
- Аймагын Засаг даргын ерөнхий данс, нөөцөөс Баяр наадмын "Үдшийн цэнгүүн-д 18.0 сая төгрөг, "Мөнгөн үдэш-2025" шинэ жилийн арга хэмжээнд 24.7 сая төгрөг, нийт 42.7 сая төгрөгийг зарцуулсан, гарын бэлэг, дурсгалын зүйлд 75.8 сая төгрөг, спортын тэмцээн уралдаан зохион байгуулахад 2.4 сая төгрөг, хоолны зардалд өмнөх оноос 50,8 хувиар их буюу 108.4 сая төгрөгийг зарцуулсан зөрчилд уг зөрчлийг таслан зогсоож, цаашид давтан гаргахгүй байх албан шаардлага, зөвлөмж өгч шийдвэрлэв.

ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

- Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татварын болон татварын бус орлогыг аймаг, сумдын ИТХ-ын хуралдаанаас нийт 91,386.8 сая төгрөгөөр тодотгон баталж гүйцэтгэлээр нийт 112,059.8 сая төгрөгийг төвлөрүүлж, батлагдсан төлөвлөгөөг 20,673.0 сая төгрөгөөр буюу 122,6 хувиар давуулан биелүүлсэн байна.
- Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 онд зарцуулахаар батлагдсан нийт зардал төсвийн гүйцэтгэлийн тайлангаар 153,878.8 сая төгрөг буюу 75,7 хувийг зарцуулсан байна. Энэ нь улсын төсвийг алдагдалгүй байлгаж орлого, зарлагын тэнцвэрийг хангаснаар төсвийн суурь зарлага урьд оноос буурч батлагдсан байна. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд зарим зардлуудыг царцааж, бууруулсан, улсын төсвийн орлого төвлөрүүлэлттэй холбогдуулан 2025 оны 10 сараас төсвийн хэмнэлтийн горимд шилжиж, төсвийн зарцуулах эрхийг эрэмбэлэн нээж, төсвийн хөрөнгө оруулалтын зардлуудыг хязгаарласан нь тус тус нөлөөлжээ.
- Төсвийн орлогын эх үүсвэрийг тэлэх, бааз суурийг нэмэгдүүлэх, татварын өрийн дутуу төлөлтийг барагдуулах талаар зохион байгуулалттай арга хэмжээ авч ажилласнаар улсын төсвөөс санхүүгийн дэмжлэг авахгүйгээр төлөвлөсөн хөтөлбөр, арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэх боломж бүрдсэн байна.
- Оны эцсийн байдлаар 45,892.7 сая төгрөгийн татварын өрнөөс улсын төсвийн өр 25,882.5 сая төгрөг, орон нутгийн төсвийн өр нь 20,010.3 сая төгрөг байна.

ЗӨВЛӨМЖ:



Аудитын дүн, дүгнэлт, нотлох зүйлд үндэслэн Аймгийн Засаг дарга Л.Төмөрчөдөр, Санхүү, Төрийн сангийн хэлтсийн дарга Ю.Бямбацогт нарт зөвлөх нь:

- Төсвийн төслийг бодит тооцоо судалгаанд үндэслэн боловсруулж, төсвийн орлогыг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллах.

Аймгийн Татварын газрын дарга Д.Мөнх-Учралд зөвлөх нь:

- Татварын орлогыг зохих нэр төрөл дээр төлөвлөж, тайлагнаж ажиллах.
- Өмнөх оны татварын өрийг барагдуулах ажлыг зохион байгуулж ажиллах.

Тайлан хянасан:

Дарга, Тэргүүлэх аудитор		Ц.Хишигжаргал
Аудитын менежер		О.Амаржаргал
Ахлах аудитор		Т.Хүрэлбаатар
Аудитор		Д.Бямбасүрэн

Тайлан бичсэн:

4117144522
ННОА0064 9060464

Холбогдох байгууллагын санал:



ТӨВ АЙМГИЙН
ТАТВАРЫН ГАЗАР

Номт 1 дүгээр баг, Зуунмод сум, Төв аймаг, 41111
Утас: 70273869, Цахим хаяг: tuv@mta.gov.mn

2026. 04. 23 № 05/93
танай _____-ны № _____-т

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Аймгийн 2025 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Аудитын тайлангаар гарах зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч хамтран ажиллах болно.

ДАРГА

Д. МӨНХ-УЧРАЛ



2026052264
My doc: Toot.A5-2025



**ТӨВ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗАР**

Номг 1 дүгээр баг, Зуунмод сум, Төв аймаг, 41111
Утас: 70273623, Цахим шуудан: tuv_zdtg@tov.gov.mn

2026.04.23 № 05/552
танай _____ -ны № _____ -г

**ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ**

Аймгийн 2025 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Аудитын тайлангаар гарах зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч хамтран ажиллах болно.

САНХҮҮ, ТӨРИЙН ЗАНГИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА  Ю.БЯМБАЦОГТ



My.Doc A5 2026 Ultra Sp
4126020541